



**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ-ЫН  
СУВГИЙН ДОМКРАТ ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: **СУВГИЙН ДОМКРАТ ХУДАЛДАН АВАХ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: **ЗТГОНӨААТҮГ /202006025**

**2020 ОН**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос /СУВГИЙН ДОМКРАТ/ нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /ADOBE PDF/шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.

Тендерийн дугаар: ЗТГОНӨААТҮГ/202006025

Батлагдсан төсөвт өртөг: 35,000,000 төгрөг

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минут ]**-аас өмнө цахим тендер шалгаруулалтын журмаар авна.

Үнийн саналыг цахим тендерийн журмаар **[2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 30 минут]**-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Тээвэрчдийн гудамж, өөрийн байр- 302, Утас: 95105188

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**байх  
хугацаа**

**7. Санал  
болгосон  
үнэ,  
түүнийг  
үнэлэх**

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ  
байгуулах  
эрх олгох  
тухай  
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
ТӨӨЗ 1.1	Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, шимтгэл, төлбөрөө тухайн тендер ирүүлсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч илрүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер ирүүлсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: <p align="center">Үнийн саналыг <b>[2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минут ]</b>-аас өмнө цахим тендер шалгаруулалтын журмаар авна.</p> <p align="center">Үнийн саналыг цахим тендерийн журмаар <b>[2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 30 минут]</b>-т нээнэ.</p>
ТӨӨЗ 2.3	Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: өргүй байх</li> <li>2. Борлуулалтын хэмжээ:шаардахгүй</li> <li>3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх, жилийн тоо: шаардахгүй</li> <li>4. Улсын бүртгэлийн гэрчилгээ, нотариатаар баталгаажуулах</li> <li>5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> </ol>
ТӨӨЗ 3.1.	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримт тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэртэй байна. <ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн санал</li> <li>2. Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь</li> </ol>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны нэр: “СУВГИЙН ДОМКРАТ”

2. Тоо ширхэг: 1 ком

Нийлүүлэгдэх бараа, бүтээгдэхүүн нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

№	Барааны нэр	Техникийн үзүүлэлт
1	Өргөх дээд жин /Т/	15-50
2	Өргөх эргэлт /мм/	500
3	Хамгийн бага өндөр /мм/	1300
4	Хүчдэл /В/	380
5	Моторын хүчин чадал /кв/	2,2

Уг бараа нь үйлдвэрлэгчийн шалгаж туршсан баталгаа сертификаттай байна.

**Барааг тодорхойлох бичиг баримт:** Тендерт оролцогчийн санал болгох бүтээгдэхүүн нь техникийн тодорхойлолтод заасантай нийцэж байгааг үйлдвэрлэгчээс нь ирүүлсэн холбогдох зураг, чанарын сертификат, шаардлагатай бусад бичиг баримтаар баталгаажуулж тендерийн саналдаа хавсаргана. Мөн үйлдвэрлэгчийн нэр, хаяг, үйлдвэрлэсэн огноо, цэвэр жин зэргийг тодорхой заасан гарал үүслийн гэрчилгээг ирүүлнэ. Барааны баталгаат хугацаа 1 жилээр гарган албан бичгээр ирүүлнэ.

**Барааг шалгаж, хүлээн авах:** Нийлүүлж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээс олгосон техникийн паспорт дагалдуулан ирүүлнэ. Барааг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын агуулахад нийлүүлэгчийн төлөөлөгч хүргэж ирж, хүлээлгэн өгнө. Техникийн паспортгүй, чанарын шаардлага хангаагүй гэж үзсэн барааг захиалагч хүлээн авахгүй, гэрээ байгуулахгүй байх, төлбөр хийхгүй байх эрхтэй.

### Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь:

/Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө./

Бараа нийлүүлэх: Гэрээг байгуулснаас хойш ажлын 22 хоног

	Барааны тодорхойлолт	Тоо, ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг /Ажлын талбай/	Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа /Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө/
№	2	3	4	5	6	7	8
1	Сувгийн домкрат	1 ком	ширхэг	2020.09.14	2020.09.01	2020.09.14	

## Тав.ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], дор дурдсан барааг[санал болгож буй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу /тоо/ хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо, ширхэг	Нэгж, үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл /ГТН/-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс /INCOTERMS/ буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа /тоо/ жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авсанаас хойш /ГТН-д заасан тоо/ хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

- 9. Алданги оногдуулах** 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүйг ээс гэрээг цуцлах** 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

### **Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

- 1. Шалгах болон турших /ГЕН-1/** 1.1. / Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана./
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт /ГЕН-2/**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 2.2. Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэлийн хувь
- 2.3. Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт
- 2.4. Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ
- 2.5. Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ
- 2.6. Барааны гарал үүслийн гэрчилгээ

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

- 3. Баталгаат засвар /ГЕН-5/** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага
- /Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд

тусгана. /

**4. Төлбөр  
/ГЕН-7/**

7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **/тоо/** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

**5. Алданги  
оногдуулах  
/ГЕН-9/**

9.1. Алданги оногдуулах хувь: **/тоо/**

Алдангийн нийт дүн: **/тоо/**

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн хот, улс, нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хуультогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг ..... төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, ..... төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ..... төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -аас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ныөдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг ;  
Үнийн санал

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь;

Гэрээ нь энд дурдсан бараа нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын*  
*үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын*  
*үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[нийлүүлэгчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*